

LinkedIn:



**МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ДҮРЭМ /  
RULES FOR THE RESOLUTION OF CASES BY THE MONGOLIAN INTERNATIONAL  
ARBITRATION**

**Legal Notice**

This is an unofficial translation for informational purposes only and does not constitute legal advice. The author accepts no liability for any action taken solely in reliance on this translation unless separate legal advice on the application of the Rules has been provided by the author pursuant to a specific engagement agreement. For inquiries regarding such legal advice, please contact the author via LinkedIn: <https://www.linkedin.com/in/alexander-dondokov/>

**ГАРЧИГ / TABLE OF CONTENTS**

<b>НЭГ. ЕРӨНХИЙ ЖУРАМ</b>	<b>CHAPTER I. GENERAL PROVISIONS</b>
1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ	Article 1. Scope of Application
2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт	Article 2. Definitions
3 дугаар зүйл. Баримт бичиг хүргэх, хугацаа тооцох	Article 3. Service of Documents and Computation of Time Limits
4 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа эхлэх	Article 4. Commencement of Arbitral Proceedings
5 дугаар зүйл. Нэхэмжлэл ба сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн	Article 5. Amount in Dispute of the Notice of Arbitration and Counterclaim
6 дугаар зүйл. Хариу тайлбар	Article 6. Answer to the Notice of Arbitration
<b>ХОЁР. АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН</b>	<b>CHAPTER II. COMPOSITION OF THE ARBITRAL TRIBUNAL</b>
7 дугаар зүйл. Арбитрчийн тоо, томилгоо	Article 7. Number of Arbitrators and Appointment
8 дугаар зүйл. Нэг арбитрчийг томилох	Article 8. Appointment of a Sole Arbitrator
9 дүгээр зүйл. Гурван арбитрчийг томилох	Article 9. Appointment of Three Arbitrators
10 дугаар зүйл. Арбитрчид тавигдах шаардлага	Article 10. Requirements for Arbitrators
11 дүгээр зүйл. Арбитрчийг татгалзан гаргах	Article 11. Challenge of an Arbitrator
12 дугаар зүйл. Арбитрчийг нөхөн томилох	Article 12. Replacement of an Arbitrator
<b>ГУРАВ. АРБИТРЫН АЖИЛЛАГАА</b>	<b>CHAPTER III. ARBITRAL PROCEEDINGS</b>
13 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны журам тогтоох	Article 13. Establishing the Procedure for the Arbitral Proceedings
14 дүгээр зүйл. Арбитрын ажиллагааны харьяалал	Article 14. Seat of the Arbitral Proceedings
15 дугаар зүйл. Маргааны харьяалал	Article 15. Jurisdiction over the Dispute
16 дугаар зүйл. Арбитрын ажиллагааг нэгтгэх, оролцогч нэмэгдэх	Article 16. Consolidation of Arbitral Proceedings; Joinder of Additional Parties
17 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны хэл	Article 17. Language of the Arbitral Proceedings
18 дугаар зүйл. Талуудын тэгш байдал	Article 18. Equality of the Parties
19 дүгээр зүйл. Нотлох баримт	Article 19. Evidence
20 дугаар зүйл. Арбитрын хуралдаан	Article 20. Arbitral Hearing
21 дүгээр зүйл. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ болон яаралтай арбитрч томилох	Article 21. Measures to Secure Enforcement and Appointment of an Emergency Arbitrator
22 дугаар зүйл. Татгалзах эрхээ алдах	Article 22. Waiver of the Right to Object
<b>ДӨРӨВ. АРБИТРЫН ШИЙДВЭР</b>	<b>CHAPTER IV. ARBITRAL DECISIONS</b>
23 дугаар зүйл. Арбитрын шийдвэр, тогтоол гаргах	Article 23. Rendering Arbitral Decisions and Orders
24 дүгээр зүйл. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, нэмэлт шийдвэр гаргах, тайлбарлах	Article 24. Correction, Additional Award and Interpretation of the Arbitral Award
25 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ	Article 25. Applicable Rules of Law
26 дугаар зүйл. Арбитрын зардал	Article 26. Arbitration Costs
27 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа дуусгавар болох	Article 27. Termination of the Arbitral Proceedings
<b>ТАВ. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ</b>	<b>CHAPTER V. OTHER PROVISIONS</b>
28 дугаар зүйл. Түргэвчилсэн ажиллагаа	Article 28. Expedited Procedure
29 дүгээр зүйл. Нууцлал	Article 29. Confidentiality
30 дугаар зүйл. Хариуцлага	Article 30. Liability

**ORIGINAL (MONGOLIAN)**

**ENGLISH TRANSLATION**

*МҮХАҮТ-н дэргэдэх Монголын Олон Улсын  
Арбитрын Арбитрчдын зөвлөлийн 2024 оны 9  
дүгээр сарын 23-ны өдрийн 07 дугаар  
тогтоолын хавсралт*

*Annex to Resolution No. 07 dated 23 September  
2024 of the Council of Arbitrators of the Mongolian  
International Arbitration under the Mongolian  
National Chamber of Commerce and Industry  
(MNCCI)*

**АРБИТРЫН ХЭРЭГ ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ДҮРЭМ**

**RULES OF ARBITRAL PROCEDURE**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ  
ЖУРАМ**

**CHAPTER I. GENERAL PROVISIONS**

**1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ**

**Article 1. Scope of Application**

1.1. Талууд маргаанаа Монголын Олон Улсын Арбитр (цаашид “Арбитр” гэнэ)-аар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон эсхүл Монголын Олон Улсын Арбитрын Хэрэг хянан шийдвэрлэх дүрэм (цаашид “Дүрэм” гэнэ)-ийн дагуу шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон (маргаан үүсэхээс өмнө эсхүл дараа тохиролцсоноос үл хамааран) бол талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх Дотоодын арбитрын ажиллагаанд энэхүү Дүрмийг баримтална.

1.1. Where the Parties have agreed to submit their dispute to the Mongolian International Arbitration Centre (hereinafter the “Arbitration Centre”) or to have it resolved in accordance with the Rules of Arbitral Procedure of the Mongolian International Arbitration Centre (hereinafter the “Rules”), whether such agreement is made before or after the dispute has arisen, these Rules shall apply to domestic arbitral proceedings for the resolution of disputes arising between the Parties.

1.2. Олон улсын арбитрын ажиллагаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдааны Эрх Зүйн Комиссоос баталсан Арбитрын дүрэм (UNCITRAL Arbitration Rules)-ийг хэрэглэнэ. Энэхүү дүрмийг хэрэглэхтэй холбоотой удирдамжийг Арбитрчдын зөвлөл батална.

1.2. In international arbitral proceedings, the UNCITRAL Arbitration Rules, as adopted by the United Nations Commission on International Trade Law, shall apply. The Council of Arbitrators shall approve guidelines on the application of those Rules.

1.3. Энэхүү Дүрэм нь 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд өөрөөр тохиролцоогүй бол уг өдрөөс хойш эхэлсэн арбитрын ажиллагаанд энэхүү Дүрмийг баримтална.

1.3. These Rules shall enter into force on 1 November 2024 and, unless the Parties agree otherwise, shall apply to arbitral proceedings commenced on or after that date.

**2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт**

**Article 2. Definitions**

2.1. Энэ Дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1. For the purposes of these Rules, the following terms shall have the meanings set out below:

- 2.1.1. “Арбитрын бүрэлдэхүүн” гэж тухайн маргааныг шийдвэрлэх нэг буюу хэд хэдэн арбитрчийг;
- 2.1.2. “Нэхэмжлэгч” гэж арбитрын ажиллагааг эхлүүлэхээр нэхэмжлэл гаргасан нэг буюу хэд хэдэн этгээд, тэдгээртэй арбитрын ажиллагааг нэгтгэх эсхүл өөр хэлбэрээр нэгдэн нийлсэн этгээдийг;
- 2.1.3. “Хариуцагч” гэж Нэхэмжлэгчийн нэхэмжлэлд дурдсан Хариуцагч, хамтран Хариуцагч, тэдгээртэй арбитрын ажиллагааг нэгтгэх эсхүл өөр хэлбэрээр нэгдэн нийлсэн этгээдийг;
- 2.1.4. “Арбитрын ажиллагааны оролцогч” гэж Талууд, тэдгээрийн Төлөөлөгч болон арбитрын ажиллагаанд оролцож буй гэрч, хэлмэрч, орчуулагч, шинжээчийг;
- 2.1.5. “Талууд” гэж Нэхэмжлэгч, Хариуцагчийг;
- 2.1.6. “Бусад оролцогч” гэж Нэхэмжлэгч, Хариуцагчаас Бусад оролцогчийг;
- 2.1.7. “Төлөөлөгч” гэж Талуудын итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, баримт бичгийн үндсэн дээр төлөөлөх эрх бүхий этгээд болон тэдгээрийн томилсон хуулийн зөвлөх, өмгөөлөгч, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгчийг бүгдийг эсхүл аль нэгийг;
- 2.1.8. “Арбитрын ажиллагаанд мэдэгдсэн хаяг” гэж арбитрын ажиллагааны явцад Баримт бичиг, мэдэгдэл хүлээн авахаар Талуудаас мэдэгдсэн хаяг;
- 2.1.9. “Арбитрын эрх бүхий этгээд” гэж Арбитрчдын зөвлөлөөс томилсон этгээдийг;
- 2.1.10. “Хүндэтгэн үзэх шалтгаан” гэж хүндээр өвчилсөн буюу эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон зэрэг өөрөөс үл хамаарах шалтгаанаар арбитрын
- 2.1.1. “Arbitral Tribunal” means one or more arbitrators appointed to decide the dispute;
- 2.1.2. “Claimant” means one or more persons who have filed a Notice of Arbitration to commence arbitral proceedings, including any person who has been joined to the proceedings by consolidation or otherwise;
- 2.1.3. “Respondent” means the respondent or co-respondent named in the Claimant’s Notice of Arbitration, including any person who has been joined to the proceedings by consolidation or otherwise;
- 2.1.4. “Participant in the Proceedings” means the Parties, their Representatives, and any witnesses, interpreters, translators and experts participating in the arbitral proceedings;
- 2.1.5. “Parties” means the Claimant and the Respondent;
- 2.1.6. “Other Participant” means any participant other than the Claimant and the Respondent;
- 2.1.7. “Representative” means any or all of: [i] a person entitled to represent a Party without a power of attorney; [ii] a person authorised to represent a Party on the basis of documentary evidence of authority; and/or [iii] any legal adviser, advocate or legal service provider appointed by any such person;
- 2.1.8. “Address Notified for the Proceedings” means the address notified by a Party during the proceedings for receipt of Documents and notices;
- 2.1.9. “Arbitral Authority” means the person appointed by the Council of Arbitrators;
- 2.1.10. “Good Cause” means circumstances beyond a person’s control that make it impossible to participate in the proceedings in person or remotely, such as

- ажиллагаанд биечлэн болон цахимаар оролцох боломжгүй нөхцөл байдлыг; serious illness or hospitalisation, or the occurrence of a sudden and irresistible event;
- 2.1.11. “Арбитрын ажиллагааны харьяалал” гэж арбитрын ажиллагаа аль улсын хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах харьяаллыг; 2.1.11. “Seat of the Arbitral Proceedings” means the legal seat of the arbitral proceedings, i.e., the jurisdiction under whose laws the arbitral proceedings are conducted;
- 2.1.12. “Дүгнэлт-тайлбар” /post hearing brief/ гэж хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдож буй үйл баримтын талаарх эцсийн дүгнэлт, хууль зүйн үндэслэл бүхий санал, тайлбар; 2.1.12. “Post-Hearing Brief” means the final conclusions on the facts established by the evidence during the hearing, and the submissions and explanations setting out the legal grounds;
- 2.1.13. “Баримт бичиг” гэж цаасан дээр, эсхүл цахим, дуу, дүрсний болон бусад хэрэгслээр бичсэн буюу хадгалсан бүх төрлийн бичвэр, харилцаа холбоо, фото зураг, гар зураг, программ, өгөгдлийг; 2.1.13. “Document” means any form of writing or communication recorded or stored on paper or by electronic, audio, visual or other means, including photographs, drawings, software and data;
- 2.1.14. “Харилцаа холбооны бусад хэрэгсэл” гэж Мэдээллийн өгөгдөл ашигласан аливаа харилцааг; 2.1.14. “Other Means of Communication” means any communication made using a Data Message;
- 2.1.15. “Мэдээллийн өгөгдөл” гэж цахим, соронзон, гэрлийн болон бусад ижил төстэй арга хэлбэрээр бий болгосон, илгээсэн, хүлээн авсан, эсхүл хадгалсан мэдээлэл цахим өгөгдөл солилцоо, цахим шуудан, телекс, телефакс, нийгмийн сүлжээг; 2.1.15. “Data Message” means information generated, sent, received or stored by electronic, magnetic, optical or similar means, including electronic data interchange, email, telex, telefax and social networks;
- 2.1.16. “Хүргэсэн” гэж Баримт бичиг, мэдэгдлийг хүлээн авагчийн хаягаар шуудан болон Харилцаа холбооны бусад хэрэгслээр илгээж, хүлээн авагч хүлээн авах боломжтой нөхцөл бүрдсэнийг; 2.1.16. “Delivered” means that a Document or notice has been sent to the recipient’s address by mail or Other Means of Communication in such a manner that the recipient is able to receive it;
- 2.1.17. “Бүртгэгч” гэж Арбитрын ажлын албаны нэхэмжлэл хүлээн авч бүртгэл хөтлөх чиг үүргийг хариуцсан ажилтныг хэлнэ; 2.1.17. “Registrar” means the staff member of the Arbitration Centre office responsible for receiving Notices of Arbitration and maintaining the registry;
- 2.1.18. “Олон улсын арбитрын ажиллагаа” гэж Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.21 дахь хэсэгт заасныг ойлгоно; 2.1.18. “International Arbitral Proceedings” has the meaning set out in Article 3, paragraph 3.21 of the Law on Arbitration;

2.1.19. “Дотоодын арбитрын ажиллагаа” гэж Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.42 дэх хэсэгт заасныг ойлгоно.

2.1.19. “Domestic Arbitral Proceedings” has the meaning set out in Article 3, paragraph 3.42 of the Law on Arbitration;

### **3 дугаар зүйл. Баримт бичиг хүргэх, хугацаа тооцох**

### **Article 3. Service of Documents and Computation of Time Limits**

3.1. Энэхүү Дүрмийн дагуу илгээх Баримт бичиг, мэдэгдлийг доорх байдлаар хүргэсэн тохиолдолд тэдгээрийг хүлээн авсанд тооцно. Үүнд:

3.1. Documents and notices sent under these Rules shall be deemed received if delivered as follows:

3.1.1. хүлээн авагч талд биечлэн хүргэснээр, эсхүл Арбитрын ажиллагаанд мэдэгдсэн хаяг баталгаат шуудангаар хүргэснээр;

3.1.1. by personal delivery to the receiving party, or by registered mail to the address notified for the Arbitral proceedings;

3.1.2. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад зааснаар хүргэх боломжгүй бол бүртгэлтэй эсхүл үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнга оршин байгаа газрын хаягт баталгаат шуудангаар илгээснээр;

3.1.2. where delivery under clause 3.1.1 is not possible, by registered mail to the address of the recipient’s registration, place of business or habitual residence;

3.1.3. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад зааснаар хүргэх боломжгүй бол холбогдох гэрээнд дурдсан хаягт баталгаат шуудангаар, факс дугаар эсхүл цахим шууданд илгээснээр;

3.1.3. where delivery under clause 3.1.2 is not possible, by registered mail to the address specified in the relevant contract, or by sending to the fax number or email address specified therein;

3.1.4. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3 дахь заалтуудад зааснаар хүргэх боломжгүй бол хамгийн сүүлд мэдэгдэж байсан хаягт баталгаат шуудангаар илгээснээр, эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан цахим шуудан, Харилцаа холбооны бусад хэрэгсэл ашиглаж илгээснээр.

3.1.4. where delivery under clauses 3.1.1-3.1.3 is not possible, by registered mail to the last known address, or by sending to the last known email address or via Other Means of Communication;

3.2. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу Баримт бичиг, мэдэгдлийг Хүргэсэн, эсхүл илгээсэн өдөр нь түүнийг хүлээн авсан өдөрт тооцогдоно.

3.2. For the purposes of clause 3.1 of this Article, the day on which a Document or notice is Delivered or sent shall be deemed the day of receipt.

3.3. Дүрмийн дагуу явагдах арбитрын ажиллагааны хугацааг Талууд өөрөөр тохиролцоогүй бол Монгол Улсын Нийслэл Улаанбаатарын цагаар буюу UTC+8 цагийн бүсээр тооцно.

3.3. Unless the Parties agree otherwise, time limits under these Rules shall be calculated by reference to the time in Ulaanbaatar, Mongolia (UTC+8).

3.4. Хэд хэдэн Нэхэмжлэгч, Хариуцагч оролцож байгаа тохиолдолд мэдэгдэл, баримт бичгийг энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу хамгийн сүүлийн хүлээн авагчид хүргэснээр тухайн Нэхэмжлэгч, Хариуцагч тус тус хүлээн авсанд тооцно.

3.5. Нэхэмжлэгч, Хариуцагч нь аливаа баримт бичгийн нэг хувийг Арбитрын хэргийн хавтаст зориулан, хуулбарыг Арбитрын бүрэлдэхүүн, Нэхэмжлэгч, Хариуцагчийн тоогоор хувилж Арбитрт ирүүлнэ. Арбитрын бүрэлдэхүүн хувилж ирүүлэх тоог өөрөөр тогтоож болно.

3.6. Хугацааг хуанлийн өдрөөр тоолох бөгөөд энэхүү Дүрэмд заасан хугацаа нь баримт бичгийг хүлээн авсан эсхүл хүлээн авсан гэж тооцсон өдрийн дараагийн өдрөөс эхлэн тоолно.

3.7. Хэрэв тогтоосон хугацааны сүүлийн өдөр нь амралтын, нийтээр амрах баярын өдөр эсхүл хүлээн авагчийн оршин байгаа улс орны нийтийг хамарсан баяр, амралтын өдөр бол энэ хугацаа дараагийн ажлын өдөр дуусна.

3.4. Where there are multiple Claimants and/or Respondents, a notice or Document shall be deemed received by each Claimant and/or Respondent upon delivery to the last recipient in accordance with clause 3.1 of this Article.

3.5. The Claimant and the Respondent shall submit to the Arbitration Centre one copy of each Document for the case file and shall provide copies for the Arbitral Tribunal and for each Claimant and Respondent. The Arbitral Tribunal may determine a different number of copies.

3.6. Time limits shall be calculated in calendar days. Any time limit specified in these Rules shall run from the day following the day on which the Document is received or deemed received.

3.7. If the last day of a time limit falls on a weekend, a public holiday or a nationwide holiday in the country where the recipient is located, the time limit shall expire on the next working day.

*Тайлбар (зүүлт) <sup>1</sup>:*

*3.2. Олон улсын арбитрын ажиллагаанд дараах арбитрын ажиллагаа хамаарна:*

*3.2.1. арбитрын хэлэлцээр байгуулах үед уг хэлэлцээрийн талууд өөр өөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;*

*3.2.2. арбитрын хэлэлцээрт заасан, эсхүл түүнд тодорхойлсон арбитрын ажиллагааны харьяалал нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;*

*3.2.3. арилжааны харилцаанаас үүсэх үүргийн ихэнхийг гүйцэтгэх газар, эсхүл маргааны зүйлтэй илүү холбоотой газар нь талуудын үйл ажиллагаа явуулж*

*Footnote <sup>1</sup>:*

*3.2. International arbitral proceedings include the following:*

*3.2.1. where, at the time of concluding the arbitration agreement, the parties to that agreement conduct business in different countries;*

*3.2.2. where the seat of the arbitral proceedings (as specified or determined in the arbitration agreement) differs from the place where the parties conduct business;*

*3.2.3. where the place of performance of most obligations arising out of the commercial relationship, or the place most closely connected*

*байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх  
арбитрын ажиллагаа;*

*3.2.4. арбитрын хэлэлцээрээс үүсэх  
харилцаа нэгээс олон улсад хамаарна  
гэдгийг талууд тодорхой тохиролцсон  
тохиолдолд хийгдэх арбитрын  
ажиллагаа.*

*Тайлбар (зүүлт) <sup>2</sup>:*

*3.4. Дотоодын арбитрын ажиллагаа гэж  
олон улсын арбитрын ажиллагаанаас  
бусад арбитрын ажиллагааг ойлгоно.*

*with the subject matter of the dispute, differs from  
the place where the parties conduct business;*

*3.2.4. where the parties have expressly agreed  
that the relationship arising out of the arbitration  
agreement relates to more than one country.*

*Footnote <sup>2</sup>:*

*3.4. Domestic arbitral proceedings mean arbitral  
proceedings other than international arbitral  
proceedings.*

#### **4 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа эхлэх**

#### **Article 4. Commencement of Arbitral Proceedings**

4.1. Энэхүү Дүрмийн дагуу Нэхэмжлэгч маргаанаа арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэлээ Арбитрын ажлын албанд хүргэнэ.

4.1. In accordance with these Rules, the Claimant shall submit to the Arbitration Centre office a Notice of Arbitration requesting that the dispute be resolved by arbitration.

4.2. Нэхэмжлэл нь дараах зүйлээс бүрдэнэ:

4.2. The Notice of Arbitration shall contain the following:

4.2.1. Нэхэмжлэгчийн овог, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар, регистрийн дугаар;

4.2.1. the Claimant's surname, given name and address; where the Claimant is a legal entity, its registered name, address, seat and registration number;

4.2.2. Хариуцагчийн овог, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг эсхүл оршин байгаа газар;

4.2.2. the Respondent's surname, given name and address; where the Respondent is a legal entity, its registered name and address or seat;

4.2.3. Талуудын холбоо барих утас, цахим шуудан, шуудангийн хаяг;

4.2.3. the Parties' contact telephone number, email address and postal address;

4.2.4. нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;

4.2.4. the grounds for the Notice of Arbitration, the relief sought, and the evidence supporting it;

4.2.5. арбитрын хэлэлцээр ба маргааны харьяаллын тухай тайлбар;

4.2.5. the arbitration agreement and an explanation regarding the jurisdiction of the dispute;

- 4.2.6. нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн. 4.2.6. the amount in dispute (value) of the Notice of Arbitration.
- 4.3. Нэхэмжлэлд арбитрын үндсэн зардлыг төлсөн баримт, арбитрын хэлэлцээр, маргаан үүсэх үндэслэл болсон гэрээ, холбогдох бусад Баримт бичиг, түүнчлэн нэхэмжлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд гаргасан бол төлөөлөх эрхтэйг нотолсон баримтыг тус тус хавсаргана. 4.3. The Notice of Arbitration shall be accompanied by: proof of payment of the basic arbitration costs; the arbitration agreement; the contract giving rise to the dispute; other relevant Documents; and, where the Notice of Arbitration is filed by an authorised representative, documentary evidence of the representative's authority.
- 4.4. Арбитрын ажлын албанд ирүүлсэн нэхэмжлэлийг Бүртгэгч хүлээн авч Арбитрын бүрэлдэхүүн томилогдох хүртэл хугацаанд дараах ажиллагааг хийнэ: 4.4. Upon receipt of the Notice of Arbitration submitted to the Arbitration Centre office, the Registrar shall, until the Arbitral Tribunal is constituted, take the following actions:
- 4.4.1. Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгүүдэд заасан бүрдүүлбэрийг хангуулах; 4.4.1. ensure that the Notice of Arbitration complies with the requirements set out in Articles 4.2 and 4.3;
- 4.4.2. Арбитрын бүрэлдэхүүнийг томилохыг Талуудад мэдэгдэх, томилоогүй бол эрх бүхий этгээдээр томилуулах; 4.4.2. notify the Parties to appoint the Arbitral Tribunal and, if they fail to do so, arrange for its appointment by the Arbitral Authority;
- 4.4.3. арбитрын ажиллагааны хугацаа тоолох, сунгах, тогтоох; 4.4.3. compute, extend and set procedural time limits;
- 4.4.4. арбитрын ажиллагаа, холбогдох Дүрэм журмын талаарх мэдээллээр Талуудыг хангах; 4.4.4. provide the Parties with information regarding the arbitral proceedings and the applicable rules and procedures;
- 4.4.5. яаралтай арбитрчийг томилуулах арга хэмжээ авах; 4.4.5. take measures to appoint an emergency arbitrator;
- 4.4.6. арбитрын үндсэн зардлын хэмжээг тодорхойлох, зардлыг төлүүлэх. 4.4.6. determine the amount of the basic arbitration costs and arrange for payment thereof.
- 4.5. Нэхэмжлэлийг Хариуцагч хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ. Хүлээн авсан өдрийг Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу тогтооно. 4.5. The arbitral proceedings shall commence on the date on which the Respondent receives the Notice of Arbitration. The date of receipt shall be determined in accordance with Article 3.2 of these Rules.

4.6. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр дутуу гэдэг үндэслэлээр Арбитрын бүрэлдэхүүн томилогдоход саад болохгүй. Үүнтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн эцэслэн шийдвэрлэнэ.

4.6. Any deficiency in the Notice of Arbitration shall not prevent the constitution of the Arbitral Tribunal. Any dispute arising in this regard shall be finally decided by the Arbitral Tribunal.

4.7. Арбитрын ажиллагааг удаашруулах, аль нэг талд ялгавартай байдлыг үүсгэх үр дагавартай гэж Арбитрын бүрэлдэхүүн үзсэнээс бусад тохиолдолд арбитрын ажиллагааны аль ч шатанд Талууд нэхэмжлэлийн шаардлага болон хариу тайлбарт нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

4.7. At any stage of the arbitral proceedings, the Parties may amend or supplement the relief sought in the Notice of Arbitration and/or the Answer to the Notice of Arbitration, unless the Arbitral Tribunal considers that such amendment would unduly delay the proceedings or result in unequal treatment of any party.

## **5 дугаар зүйл. Нэхэмжлэл ба сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн**

## **Article 5. Amount in Dispute of the Notice of Arbitration and counterclaim**

5.1. Бүртгэгч эсхүл Арбитрын бүрэлдэхүүн арбитрын үндсэн зардлын хэмжээг тогтоох зорилгоор нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүнг дараах байдлаар тодорхойлж болно:

5.1. For the purpose of determining the amount of the basic arbitration costs, the Registrar or the Arbitral Tribunal may determine the amount in dispute (value) of the Notice of Arbitration and/or counterclaim as follows:

5.1.1. Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бол түүний дүнгээр;

5.1.1. where expressed in monetary terms, by the amount claimed;

5.1.2. Гэрээ хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах бол уг гэрээ хэлцлийн үнийн дүнгээр;

5.1.2. where the Notice of Arbitration seeks a declaration that a contract or transaction is invalid, by the value of such contract or transaction;

5.1.3. Эд хөрөнгө гаргуулах бол уг эд хөрөнгийн үнийн дүнгээр, үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр;

5.1.3. where the Notice of Arbitration seeks delivery or restitution of property, by the value of such property; if the value cannot be determined, by the average market price at the relevant time;

5.1.4. Эрхийн харилцааг хүлээн зөвшөөрөх буюу өөрчлөх бол тухайн эрхийн шаардлага гаргах үеийн үнэлгээгээр;

5.1.4. where the Notice of Arbitration seeks recognition or modification of a legal right or legal relationship, by its valuation at the time the Notice of Arbitration is filed;

5.1.5. Тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг даалгах тухай шаардлагын хувьд тухайн шаардлагад хамаарах хөрөнгийн сонирхолд үндэслэсэн дүнгээр;

5.1.5. where the Notice of Arbitration seeks an order to do or refrain from doing a specific act, by an amount based on the pecuniary interest involved;

5.1.6. Хэд хэдэн шаардлага тавьсан нэхэмжлэлд, шаардлага бүрийн үнийн дүнг тус бүрд нь тодорхойлох бөгөөд нэхэмжлэлийн үнийг бүх шаардлагын нийлбэр дүнгээр тодорхойлно.

5.1.6. where multiple claims are submitted, the value of each Notice of Arbitration shall be determined separately, and the overall value of the Notice of Arbitration shall be determined by the aggregate of all Notices of Arbitration.

5.2. Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүнг тодорхойлоогүй эсхүл буруу тодорхойлсон байвал уг үнийн дүнг Арбитрын бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар эсхүл аль нэг талын хүсэлтээр тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.

5.2. Where the amount in dispute (value) of the Notice of Arbitration and/or counterclaim has not been specified or has been incorrectly specified, the Arbitral Tribunal shall determine such amount on its own initiative or at the request of a party. Where necessary, it may seek assistance from an appropriate professional organisation.

## 6 дугаар зүйл. Хариу тайлбар

## Article 6. Answer to the Notice of Arbitration

6.1. Хариуцагч нь нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоног, түргэвчилсэн журмаар маргаан шийдвэрлэх бол 7 хоногийн дотор хариу тайлбарыг Арбитрт ирүүлнэ. Хариу тайлбарт дараах мэдээллийг тусгана:

6.1. The Respondent shall submit its Answer to the Notice of Arbitration to the Arbitration Centre within 30 days of receipt of the Notice of Arbitration, or within 7 days where the dispute is resolved under the expedited procedure. The Answer to the Notice of Arbitration shall include the following information:

6.1.1. Хариуцагч, түүний Төлөөлөгчийн овог, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг эсхүл оршин байгаа газар, холбоо барих утас, цахим шуудан, шуудангийн хаяг;

6.1.1. the Respondent's and its Representative's surname, given name and address; where the Respondent is a legal entity, its registered name and address or seat; as well as contact telephone number(s), email address(es) and postal address(es);

6.1.2. арбитрын харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох тайлбар;

6.1.2. where the Respondent does not accept the jurisdiction, the relevant explanation;

6.1.3. нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч буй, эсхүл хүлээн зөвшөөрөхгүй татгалзаж буй тайлбар;

6.1.3. an explanation as to whether the Respondent accepts the relief sought in the Notice of Arbitration or rejects it;

- 6.1.4. хариу тайлбарыг дэмжиж буй үйл баримт, хууль зүйн үндэслэл; 6.1.4. the factual and legal grounds supporting the Answer to the Notice of Arbitration;
- 6.2. Хариу тайлбарыг төлөөлөх эрх бүхий этгээд гаргах ба төлөөлөх эрхтэйг нотолсон баримтыг хавсаргана. 6.2. The Answer to the Notice of Arbitration shall be submitted by a duly authorised person, and documentary evidence of such authority shall be attached.
- 6.3. Хариуцагч нь хариу тайлбараа Арбитрт ирүүлэх бөгөөд Арбитр нь хариу тайлбарын хувийг Нэхэмжлэгчид хүргэнэ. 6.3. The Respondent shall submit its Answer to the Notice of Arbitration to the Arbitration Centre, and the Arbitration Centre shall serve a copy of the Answer to the Notice of Arbitration on the Claimant.
- 6.4. Хариуцагч нь хариу тайлбарыг тогтоосон хугацаанд Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй нь арбитрын ажиллагааг үргэлжлүүлэхэд саад болохгүй. 6.4. Failure by the Respondent to submit the Answer to the Notice of Arbitration within the prescribed time limit without Good Cause shall not prevent the arbitral proceedings from continuing.
- 6.5. Хариуцагч үндсэн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. 6.5. The Respondent has the right to submit a counterclaim in respect of matters related to the principal Notice of Arbitration. The counterclaim shall comply with the requirements set out in Article 4.2 of these Rules.
- 6.6. Нэмэгдүүлсэн шаардлага, сөрөг нэхэмжлэлийн шаардлагад Талууд Арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд хариу тайлбар ирүүлнэ. 6.6. The Parties shall submit responses to any amended relief sought and/or to any counterclaim within the time limits set by the Arbitral Tribunal.
- 6.7. Хариуцагч хариу тайлбар гаргаагүй, дутуу эсвэл хугацаа хожимдуулсан нь Арбитрын бүрэлдэхүүнийг томилоход саад учруулах үндэслэл болохгүй ба үүнтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн эцсийн шийдвэрийг гаргана. 6.7. The Respondent's failure to submit an Answer to the Notice of Arbitration, or submission of an incomplete or late Answer to the Notice of Arbitration, shall not constitute grounds to prevent the constitution of the Arbitral Tribunal. If any dispute arises in this regard, the Arbitral Tribunal shall render a final decision.

## ХОЁР. АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН

## CHAPTER II. COMPOSITION OF THE ARBITRAL TRIBUNAL

### 7 дугаар зүйл. Арбитрчийн тоо, томилгоо

### Article 7. Number of Arbitrators and Appointment

7.1. Дүрмийн дагуу маргааныг хянан шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний тоо нэг, эсхүл гурав байна. Талууд маргааныг хянан шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний тоог харилцан тохиролцоогүй бөгөөд маргааныг түргэвчилсэн журмаар шийдвэрлэхээс бусад тохиолдолд тухайн маргааныг шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний тоо гурав байна.

7.2. Маргааныг түргэвчилсэн журмаар шийдвэрлэж байгаа тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүний тоог Дүрмийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад заасны дагуу тогтоож томилно.

7.3. Талууд арбитрчийг Арбитрын арбитрчдын жагсаалтаас сонгож томилно. Арбитр нь арбитрчийн ажлын туршлага, мэргэжлийн ур чадварын талаар нээлттэй мэдээлнэ.

7.4. Арбитрын эрх бүхий этгээд нь арбитрчийг томилохдоо Талуудын шаардлагыг хангаж байгаа эсэх, арбитрчийн туршлага, мэргэшсэн байдал, ажиллах боломж болон бусад байдлыг харгалзан үзнэ.

7.5. Энэхүү Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.4 дэх хэсэгт тус тус заасан асуудлаар гаргасан Арбитрын эрх бүхий этгээдийн шийдвэр эцсийн байна.

7.6. Энэхүү Дүрэмд заасан хугацаанд эсхүл нэхэмжлэл гаргах, хариу тайлбар өгөхдөө арбитрч томилох саналыг арбитрт ирүүлж болно.

## **8 дугаар зүйл. Нэг арбитрчийг томилох**

8.1. Талууд арбитрчийн тоог нэг байхаар тохиролцсон, эсхүл аль нэг тал нь санал гаргасан, тухайн саналыг нөгөө тал нь хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор татгалзаагүй

7.1. Under these Rules, the Arbitral Tribunal deciding a dispute shall consist of one or three arbitrators. Unless the Parties have agreed on the number of arbitrators and except where the dispute is resolved under the expedited procedure, the Arbitral Tribunal deciding the dispute shall consist of three arbitrators.

7.2. Where the dispute is resolved under the expedited procedure, the number of members of the Arbitral Tribunal shall be determined and the arbitrator(s) appointed in accordance with clause 28.3.1 of Article 28 of these Rules.

7.3. The Parties shall select and appoint arbitrators from the Arbitration Centre's list of arbitrators. The Arbitration Centre shall make publicly available information on the arbitrators' work experience and professional qualifications.

7.4. In appointing an arbitrator, the Arbitral Authority shall take into account whether the Parties' requirements are met, the arbitrator's experience, qualifications, availability and other relevant circumstances.

7.5. Any decision of the Arbitral Authority made in relation to the matters specified in clause 8.4 of Article 8 and clauses 9.1, 9.2 and 9.4 of Article 9 of these Rules shall be final.

7.6. Within the time limits specified in these Rules, or when submitting the Notice of Arbitration or the Answer to the Notice of Arbitration, the Parties may submit to the arbitration their proposal on the appointment of an arbitrator.

## **Article 8. Appointment of a Sole Arbitrator**

8.1. Where the Parties have agreed that the dispute shall be decided by a sole arbitrator, or where one Party has proposed that the dispute be decided by a sole arbitrator and the other Party does not object

тохиолдолд нэг арбитрчаар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

8.2. Талууд арбитрчийн тоог нэг байхаар тохиролцсон тохиолдолд Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилно.

8.3. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн Нэхэмжлэгч, Хариуцагч оролцох тохиолдолд арбитрын ажиллагаа эхэлснээс хойш 14 хоногийн дотор Талууд хамтран нэг арбитрчийг харилцан тохиролцож томилно.

8.4. Хэрэв Талууд Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2-8.3 дахь хэсэгт заасан хугацаанд хэргийг шийдвэрлэх нэг арбитрчийг харилцан тохиролцож томилж чадаагүй бол Арбитрын эрх бүхий этгээд арбитрчийг томилно.

#### **9 дүгээр зүйл. Гурван арбитрчийг томилох**

9.1. Талууд арбитрын ажиллагаа эхэлснээс хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилно. Энэ хугацаанд Талууд арбитрчаа томилоогүй бол Арбитрын эрх бүхий этгээд арбитрчийг томилно.

9.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол томилогдсон хоёр арбитрч нь гурав дахь арбитрчийг томилох бөгөөд ийнхүү томилогдсон гурав дахь арбитрч нь даргалагч арбитрч байна. Талуудын томилсон арбитрчид ийнхүү томилогдсоноос хойш 14 хоногийн дотор даргалагч арбитрчийг томилоогүй бол Арбитрын эрх бүхий этгээд томилно.

9.3. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн Нэхэмжлэгч, Хариуцагч оролцох тохиолдолд Талууд арбитрчийн тоог тохиролцоогүй бол Нэхэмжлэгчид хамтран нэг арбитрчийг, Хариуцагчид хамтран нэг арбитрчийг 14 хоногийн дотор тус тус томилно.

within 7 days of receipt of such proposal, the request for a sole arbitrator shall be deemed accepted.

8.2. Where the Parties have agreed on a sole arbitrator, they shall appoint the arbitrator within 14 days after expiry of the period specified in clause 8.1 of this Article.

8.3. Where the arbitral proceedings involve multiple Claimants and/or Respondents, the Parties shall jointly agree on and appoint one arbitrator within 14 days after commencement of the arbitral proceedings.

8.4. If the Parties fail to agree on and appoint a sole arbitrator within the time limits specified in clauses 8.2-8.3 of this Article, the Arbitral Authority shall appoint the arbitrator.

#### **Article 9. Appointment of Three Arbitrators**

9.1. The Parties shall appoint their arbitrator(s) within 14 days after commencement of the arbitral proceedings. If a Party fails to appoint its arbitrator within that period, the Arbitral Authority shall appoint the arbitrator.

9.2. Unless the Parties agree otherwise, the two appointed arbitrators shall appoint the third arbitrator, who shall act as the presiding arbitrator. If the presiding arbitrator is not appointed within 14 days after the two arbitrators have been appointed, the Arbitral Authority shall appoint the presiding arbitrator.

9.3. Where the arbitral proceedings involve multiple Claimants and/or Respondents and the Parties have not agreed on the number of arbitrators, the Claimants shall jointly appoint one arbitrator and the Respondents shall jointly appoint one arbitrator within 14 days, respectively.

9.4. Дүрэмд заасан хугацаанаас өмнө Талууд арбитрчаа, мөн Талуудын томилсон арбитрчид даргалагч арбитрчийг Арбитрын эрх бүхий этгээдээр томилуулах хүсэлтийг гаргаж болно.

#### **10 дугаар зүйл. Арбитрчид тавигдах шаардлага**

10.1. Арбитрч нь арбитрын ажиллагааны туршид хараат бус, бие даасан байна. Арбитрч тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ аливаа хөндлөнгийн нөлөөнд автахгүйгээр, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дайчилж ажиллана.

10.2. Арбитрчаар томилогдсон этгээд тухайн маргаанд ажиллахаа хүлээн зөвшөөрөхөөс өмнө Талуудын талаарх мэдээлэл, нэхэмжлэлтэй танилцан өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэх дараах нөхцөл байдлын талаар арбитрын ажлын албанд мэдэгдэх үүрэгтэй:

10.2.1. Талуудын харилцан тохиролцсон шаардлагыг хангаж байгаа эсэх;

10.2.2. Талуудтай аливаа маргаантай асуудлаар сүүлийн 2 жилийн хугацаанд шүүх, арбитраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч, гуравдагч этгээд, гэрч, шинжээч, орчуулагчаар оролцож байсан эсэх;

10.2.3. төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн холбоо, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;

10.2.4. Талуудад мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж байсан, аж ахуйн болон бусад хэлбэрээр нэгдмэл сонирхолтой эсэх;

10.2.5. бусад нөхцөл байдлын улмаас хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээтэй эсэх.

9.4. Before expiry of the time limits specified in these Rules, the Parties may request that their arbitrator(s), and/or the presiding arbitrator to be appointed by the arbitrators appointed by the Parties, be appointed by the Arbitral Authority.

#### **Article 10. Requirements for Arbitrators**

10.1. An arbitrator shall be independent and impartial throughout the arbitral proceedings. In deciding the dispute, the arbitrator shall not be influenced by any improper interference and shall apply the arbitrator's professional knowledge and skills.

10.2. A person appointed as an arbitrator shall, before accepting the appointment, review the information relating to the Parties and the Notice of Arbitration and shall disclose to the arbitration office any of the following circumstances that may give rise to doubts as to the arbitrator's independence or impartiality:

10.2.1. whether the arbitrator meets the requirements agreed between the Parties;

10.2.2. whether, in any disputed matter involving the Parties, the arbitrator has, within the last two years, participated in court or arbitral proceedings as a party, third party, witness, expert or translator/interpreter;

10.2.3. whether there are any kinship/family ties, any employment or official ties, any property/financial ties, or any conflict of interest;

10.2.4. whether the arbitrator has provided professional advice or services to any Party, or has any common interest with a Party through business or other association;

10.2.5. whether, due to other circumstances, there are justified doubts as to the arbitrator's ability to decide the case fairly.

10.3. Арбитрч арбитрын ажиллагааны явцад өмнө нь мэдэгдэж байснаас бусад хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлж болох нөхцөл байдал илэрсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлын талаар арбитрын ажиллагааны аль ч үед Арбитр болон Талуудад нэн даруй бичгээр мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлдээ арбитрчаар ажиллах, эсхүл татгалзах тухай саналаа тусгана.

10.4. Арбитрчийн ажиллах боломж, бие даасан, хараат бус байдлын талаарх мэдээллийг Талууд арбитрчийг томилохоос өмнө, хэрэв арбитрчийг Арбитрын эрх бүхий этгээд томилсон бол томилсон тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Арбитраар дамжуулан авч болно.

10.5. Талууд болон түүний Төлөөлөгчид нь арбитрчтай тухайн арбитрын ажиллагаатай холбоотой асуудлаар ганцаарчилсан уулзалт хийх, холбогдох, зүй бус нөлөөлөхийг хориглоно. Энэ талаар тухайн арбитрч Арбитрт мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэн нь арбитрчаас татгалзах үндэслэл болохгүй.

## 11 дүгээр зүйл. Арбитрчийг татгалзан гаргах

11.1. Аль нэг арбитрчийн хараат бус, бие даасан байдлын талаар үндэслэл бүхий эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал бий болсон гэж үзвэл тухайн арбитрчийг татгалзан гаргаж болно.

11.2. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтэй тал нь Дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын талаар мэдсэн болон мэдэх боломжтой байсан өдрөөс хойш 14 өдрийн дотор татгалзан гаргах үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр үйлдэн Арбитрын бүрэлдэхүүнд гаргана.

11.3. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг нөгөө тал зөвшөөрөөгүй, эсхүл тухайн

10.3. If, during the arbitral proceedings, any circumstance arises (other than those previously disclosed) that may give rise to doubts as to an arbitrator's independence or impartiality, the arbitrator shall promptly notify the Arbitration Centre and the Parties in writing at any time during the proceedings, and shall state in such notice whether the arbitrator proposes to continue to act or to withdraw.

10.4. The Parties may obtain, through the Arbitration Centre, information on an arbitrator's availability and independence/impartiality prior to the appointment; where the arbitrator is appointed by the Arbitral Authority, the Parties may obtain such information within 14 days after receipt of the decision on appointment.

10.5. The Parties and their Representatives shall be prohibited from engaging in any *ex parte* meeting or communication with an arbitrator in relation to the arbitral proceedings and from exerting any improper influence. The arbitrator shall notify the Arbitration Centre thereof, and such notification shall not, in itself, constitute grounds for challenging the arbitrator.

## Article 11. Challenge of an Arbitrator

11.1. Where circumstances exist that give rise to justified doubts as to an arbitrator's independence or impartiality, that arbitrator may be challenged.

11.2. A Party intending to challenge an arbitrator shall, within 14 days from the date on which it became aware or could have become aware of the circumstances referred to in clause 11.1 of this Article, submit a reasoned written request for challenge to the Arbitral Tribunal.

11.3. Unless the other Party agrees to the challenge or the challenged arbitrator withdraws voluntarily, the

арбитрч өөрийн хүсэлтээр татгалзан гараагүй бол тухайн арбитрачийг оролцуулалгүйгээр Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Хэрэв арбитрачийг татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэхэд Арбитрын бүрэлдэхүүний санал зөрсөн, эсхүл Арбитрын бүрэлдэхүүнээс бүхэлд нь татгалзсан бол татгалзан гаргах хүсэлтийг Арбитрын эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

11.4. Арбитрчаас татгалзан гаргах хүсэлтийг нөгөө тал зөвшөөрсөн бол тухайн арбитрачийг татгалзсан гэж үзнэ.

11.5. Арбитрачийг татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй бол Арбитрын бүрэлдэхүүн арбитраж ажиллагааг үргэлжлүүлж, үндсэн шийдвэр гаргаж болно.

11.6. Арбитрачийг татгалзан гаргах хүсэлтэд дурдсан үндэслэл байхгүй гэж үзвэл арбитраж өөрийн хүсэлтээр татгалзан гарах эрхгүй.

11.7. Аль нэг талын хүсэлтийн дагуу арбитражийг татгалзан гаргасан нь даргалагч арбитраж болон бусад арбитражийг өөрчлөх, татгалзан гаргах үндэслэл болохгүй.

## 12 дугаар зүйл. Арбитражийг нөхөн томилох

12.1. Татгалзан гаргах хүсэлтийг хүлээн авсан, өөрийн хүсэлтээр татгалзан гарсан арбитражийг анх томилоход үйлчилж байсан журмын дагуу шинээр нөхөн томилно.

12.2. Арбитраж нөхөн томилогдсон тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр шийдвэрлээгүй бол арбитраж нөхөн томилогдсон үеэс арбитраж ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.

12.3. Арбитраж нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан, эрх, үүргээ хэрэгжүүлэх чадамжгүй болсон гэж үзвэл Арбитрын эрх бүхий этгээд тухайн арбитражийн арбитраж ажиллагааны эрх үүргийг дуусгавар болгож, энэ тухай

Arbitral Tribunal shall decide the challenge without the participation of the challenged arbitrator. If the members of the Arbitral Tribunal are divided on the decision, or if the entire Arbitral Tribunal is challenged, the challenge shall be decided by the Arbitral Authority.

11.4. If the other Party agrees to the challenge request, the arbitrator shall be deemed challenged.

11.5. If the challenge request is not upheld, the Arbitral Tribunal may continue the arbitral proceedings and render an award.

11.6. Where it is determined that the grounds stated in the challenge request do not exist, the arbitrator shall not be entitled to withdraw voluntarily.

11.7. The challenge of an arbitrator at the request of a Party shall not constitute grounds to replace or challenge the presiding arbitrator or any other arbitrator.

## Article 12. Replacement of an Arbitrator

12.1. An arbitrator who has been successfully challenged or who has withdrawn voluntarily shall be replaced in accordance with the procedure that applied to the arbitrator's original appointment.

12.2. Where an arbitrator is replaced, unless the Arbitral Tribunal decides otherwise, the arbitral proceedings shall continue from the time of such replacement.

12.3. If an arbitrator fails to perform his or her duties properly, commits an ethical breach, or becomes incapable of exercising his or her rights and duties, the Arbitral Authority shall terminate the arbitrator's mandate and shall notify the Parties and the Arbitral

Талуудад болон Арбитрын бүрэлдэхүүнд мэдэгдэнэ. Арбитрчийг Дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу нөхөн томилно.

Tribunal accordingly. The arbitrator shall be replaced in accordance with clause 12.1 of this Article.

### ГУРАВ. АРБИТРЫН АЖИЛЛАГАА

### CHAPTER III. ARBITRAL PROCEEDINGS

#### 13 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны журам тогтоох

#### Article 13. Establishing the Procedure for the Arbitral Proceedings

13.1. Арбитрын бүрэлдэхүүн нь арбитрын ажиллагааг Талуудын эрх тэгш байдал болон өөрсдийн байр суурийг илэрхийлэх боломжоор хангасан, шуурхай, үр дүнтэй, Талуудын саналыг харгалзан тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр явуулна.

13.1. The Arbitral Tribunal shall conduct the arbitral proceedings in such a manner as to ensure that the Parties are treated with equality and are given a full opportunity to present their positions, and shall conduct the arbitral proceedings expeditiously and efficiently, taking into account the views of the Parties.

13.2. Арбитрын бүрэлдэхүүн Талуудтай зөвшилцсөний үндсэн дээр боломжит богино хугацаанд арбитрын ажиллагааны бэлтгэлийг хангах, ажиллагааны явцад Талуудаас тайлбар, хүсэлт, нотлох баримт, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх цаг хугацааны хуваарийг тогтоох зорилгоор урьдчилсан хуралдааныг танхимаар болон цахимаар явуулна.

13.2. For purposes of preparing the dispute for hearing, after consultation with the Parties the Arbitral Tribunal shall hold a preliminary hearing in person or by electronic means and shall set the procedural timetable for the submission of statements, requests and evidence in respect of the Notice of Arbitration, Counterclaim, amendments and other procedural steps.

13.3. Урьдчилсан хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

13.3. At the preliminary hearing, the Arbitral Tribunal shall discuss the following matters:

13.3.1. арбитрын харьяалал;

13.3.1. the seat of the arbitral proceedings;

13.3.2. арбитрын ажиллагааны журам

13.3.2. the procedure for the arbitral proceedings;

13.3.3. Талуудаас гаргасан хүсэлт;

13.3.3. requests of the Parties;

13.3.4. арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ;

13.3.4. interim measures to secure enforcement of the arbitral award;

13.3.5. үндсэн хуралдааныг хийх хэлбэр, тов;

13.3.5. the form and date of the main hearing;

13.3.6. бусад.

13.3.6. other matters.

13.4. Арбитрын харьяаллын талаар маргаантай гэж үзвэл Арбитрын бүрэлдэхүүн тусгайлан хэлэлцэж, шийдвэр гаргана.

13.4. If a dispute arises as to jurisdiction, the Arbitral Tribunal shall consider the issue separately and render a decision thereon.

- 13.5. Урьдчилсан хуралдаанаар дараах зүйлсийг тусгасан арбитрын ажиллагааны журмыг батална:
- 13.5.1. Талууд, тэдгээрийн албан ёсны нэр, хаяг;
- 13.5.2. арбитрын ажиллагааны товч мэдээлэл;
- 13.5.3. нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэл болон хариу тайлбарын товч агуулга;
- 13.5.4. Талуудын маргаж буй зүйл ба Арбитрын бүрэлдэхүүний тогтоох шаардлагатай асуудал;
- 13.5.5. арбитрын хэлэлцээр;
- 13.5.6. арбитрын харьяалал;
- 13.5.7. нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн, арбитрын зардал;
- 13.5.8. арбитрын ажиллагаа явуулах газар;
- 13.5.9. арбитрын ажиллагаа явуулах хэл;
- 13.5.10. маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүй;
- 13.5.11. арбитрын хуралдааны тов;
- 13.5.12. арбитрын хуралдааныг явуулах арга, хэлбэр;
- 13.5.13. арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ;
- 13.5.14. арбитрын хуралдааныг цахимаар явуулах тохиолдолд цахим хурлын удирдамж;
- 13.5.15. арбитрын ажиллагаанд Төлөөлөгч, бусад этгээдийг оролцуулах, хэргийн материал, Баримт бичигтэй танилцах, тохиролцсон болон тогтоосон хугацааг баримтлах Талуудын үүрэг;
- 13.5. At the preliminary hearing, the Arbitral Tribunal shall approve a Procedural Order of the arbitral proceedings covering, inter alia, the following:
- 13.5.1. the Parties, their official names and addresses;
- 13.5.2. brief information on the arbitral proceedings;
- 13.5.3. a brief summary of the Notice of Arbitration, the counterclaim and the Answer to the Notice of Arbitration;
- 13.5.4. the matters in dispute and the issues to be determined by the Arbitral Tribunal;
- 13.5.5. the arbitration agreement;
- 13.5.6. the seat of the arbitral proceedings;
- 13.5.7. the amount of the Notice of Arbitration and the counterclaim and the arbitration costs;
- 13.5.8. the place (venue) of the arbitral proceedings;
- 13.5.9. the language of the arbitral proceedings;
- 13.5.10. the law applicable to the resolution of the dispute;
- 13.5.11. the date of the hearing;
- 13.5.12. the method and form of conducting the hearing;
- 13.5.13. interim measures to secure enforcement of the arbitral award;
- 13.5.14. where the hearing is conducted remotely, the electronic hearing guidelines;
- 13.5.15. the Parties' obligations to ensure the participation of their Representatives and other persons, access to the case file and Documents, and compliance with the time limits agreed by the Parties and/or set by the Arbitral Tribunal;

13.5.16. Талуудын гаргаж өгөх Баримт бичиг, хүсэлт, сөрөг нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх, нотлох баримт бүрдүүлэх, гэрч шинжээч, үзлэг, хэлмэрч, орчуулагч томилох, шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт, тэдгээрийг Арбитрт ирүүлэх хугацаа болон хуваарь;

13.5.17. арбитрын ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авах этгээд, хүргэх арга хэрэгсэл;

13.5.18. арбитрын ажиллагааны журмыг баталгаажуулах хэлбэр, арга хэрэгсэл.

13.6. Аль нэг тал нь арбитрын ажиллагааны журамд заасан хугацааг баримтлаагүй, тохиролцсон болон тогтоосон хугацаанд эрхээ эдлээгүй бол эрхээсээ татгалзсан буюу эрхээ эдэлсэн гэж үзнэ.

13.7. Аль нэг тал нь урьдчилсан хуралдаанаар тогтоох Арбитрын ажиллагааны журамд бичгээр санал ирүүлсэн бол Арбитрын бүрэлдэхүүн уг саналыг Арбитрын ажиллагааны журмыг батлахдаа харгалзан үзэж болно.

13.8. Урьдчилсан хуралдаанд аль нэг тал Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тохиолдолд түүний эзгүйд, хуралдаанд оролцогч талын саналыг харгалзан урьдчилсан хуралдааныг явуулж болно.

13.9. Арбитрын ажиллагааны журмыг Арбитрын бүрэлдэхүүн болон Талууд баталгаажуулна. Аль нэг тал баталгаажуулаагүй, баталгаажуулахаас татгалзсан нь журмын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

13.10. Арбитрын ажиллагаанд Арбитрын бүрэлдэхүүн ба талууд тохиролцож баталсан Арбитрын ажиллагааны журам, Арбитрын

13.5.16. the schedule and deadlines for the submission by the Parties to the Arbitration Centre of Documents, requests, counterclaims, amendments, evidence, requests for the appointment of witnesses, experts, inspection, interpreters and translators, requests for expert opinions;

13.5.17. the persons to whom information on the arbitral proceedings shall be sent and the manner of delivery;

13.5.18. the form and means of confirming the procedural order of the arbitral proceedings.

13.6. If a party fails to comply with the time limits set in the procedural order and does not exercise its procedural rights within the agreed or prescribed period, that party shall be deemed to have waived, or to have exercised, the relevant procedural right, as applicable.

13.7. If any party has submitted written proposals regarding the procedural order at the preliminary hearing, the Arbitral Tribunal may take such proposals into account when approving the procedural order.

13.8. If a party fails to attend the preliminary hearing without Good Cause, the Arbitral Tribunal may proceed in that party's absence, taking into account the views of the Party in attendance.

13.9. The procedural order shall be approved by the Arbitral Tribunal and the Parties. A Party's failure to approve, or refusal to approve, the procedural order shall not affect the validity of the procedural order.

13.10. The arbitral proceedings shall be governed by the Procedural Order agreed and approved by the Arbitral Tribunal and the Parties, these Rules, and the Law on Arbitration.

хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, Арбитрын тухай хуулийг хэрэглэнэ.

#### **14 дүгээр зүйл. Арбитрын ажиллагааны харьяалал**

14.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын ажиллагааны харьяалал Монгол Улс байна.

14.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол шаардлагатай тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөх, гэрч, шинжээч, Талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, Баримт бичигт үзлэг хийх, арбитрын хуралдаан явуулах зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа явуулах газраас өөр газар явуулж болно. Энэ нь харьяаллыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

#### **15 дугаар зүйл. Маргааны харьяалал**

15.1. Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаан нь Монголын Олон Улсын арбитрын харьяаллын маргаан мөн эсэх, Талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эсэх, арбитрын хэлэлцээрийн хүрээнд хамаарах эсэхийг өөрөө тогтоох эрхтэй.

15.2. Дараах тохиолдолд Монголын Олон Улсын Арбитрын харьяаллын маргаан гэж үзнэ:

15.2.1. Талууд Монголын Олон Улсын Арбитраар шийдвэрлүүлэх эсхүл хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх хэлэлцээртэй;

15.2.2. Монголын Олон Улсын Арбитрыг сонгосон гэж арбитрын хэлэлцээрийг тайлбарлахаар бол;

15.2.3. Арбитрын хэлэлцээрт энэхүү Дүрмийг хэрэглэхээр тохиролцсон;

#### **Article 14. Seat of the Arbitral Proceedings**

14.1. Unless the Parties have agreed otherwise, the seat of the arbitral proceedings shall be Mongolia.

14.2. Unless the Parties have agreed otherwise, where necessary the Arbitral Tribunal may conduct consultations, hear the statements of Parties, witnesses and experts, inspect goods, property and Documents, and hold hearings at a place other than the seat of the arbitral proceedings. This shall not affect the seat of the arbitral proceedings.

#### **Article 15. Jurisdiction over the Dispute**

15.1. The Arbitral Tribunal shall have the power to determine whether the dispute is within the jurisdiction of the Mongolian International Arbitration Centre, including whether the Parties have concluded an arbitration agreement, whether it is valid, and whether the dispute falls within the scope of the arbitration agreement.

15.2. The dispute shall be deemed to fall within the jurisdiction of the Mongolian International Arbitration Centre in the following cases:

15.2.1. the Parties have agreed that the Mongolian International Arbitration Centre shall resolve or administer the case;

15.2.2. the arbitration agreement may be interpreted as selecting the Mongolian International Arbitration Centre;

15.2.3. the arbitration agreement provides for the application of these Rules;

15.2.4. Арбитрын хэлэлцээрийн нэг тал нь нэхэмжлэл гаргасан бөгөөд Хариуцагч хариу тайлбар гаргах 30 хоногийн дотор харьяаллын талаар маргаагүй;

15.2.5. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон бусад мэргэжлийн холбоодын дүрэм, гэрээний нөхцөл зэрэг баримт бичигт арбитрын хэлэлцээр тусгагдсан бол тухайн байгууллагын гишүүд хооронд үүссэн маргаан;

15.2.6. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасан.

#### **16 дугаар зүйл. Арбитрын ажиллагааг нэгтгэх, оролцогч нэмэгдэх**

16.1. Дүрмийн дагуу явагдаж буй арбитрын хэд хэдэн ажиллагааг нэгтгэх хүсэлт гаргасан тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн доорх тохиолдлуудад нэгтгэж болно:

16.1.1. Талууд арбитрын ажиллагааг нэгтгэхийг хүлээн зөвшөөрсөн;

16.1.2. тухайн нэхэмжлэлүүд нь нэг арбитрын хэлэлцээрт үндэслэсэн;

16.1.3. нэхэмжлэлүүд нь хууль болон үйл баримтын хувьд нийтлэг асуудлыг хөндсөн, нэг хэлцэл эсхүл хамаарал бүхий хэд хэдэн хэлцлүүдээс үүссэн.

16.2. Хэд хэдэн ажиллагааг нэгтгэх тохиолдолд эхэнд эхэлсэн арбитрын ажиллагаанд нэгтгэнэ.

16.3. Дүрмийн дагуу явагдаж буй арбитрын ажиллагаанд гуравдагч этгээд шинээр маргааны тал болж нэмэгдэж оролцох хүсэлт гаргасан бол Арбитрын бүрэлдэхүүн Талуудын саналыг харгалзан, арбитрын хэлэлцээр, маргааны агуулга болон бусад холбогдох нөхцөл байдлуудыг харгалзан

15.2.4. one party has filed a Notice of Arbitration and the Respondent has not challenged jurisdiction within the 30-day period for submitting its Answer to the Notice of Arbitration;

15.2.5. where an arbitration agreement is incorporated in documents such as the charter or rules of the Mongolian National Chamber of Commerce and Industry or other professional associations, or contractual terms, and the dispute arises between members of such organisation;

15.2.6. as provided in the laws of Mongolia and international treaties.

#### **Article 16. Consolidation of Arbitral Proceedings; Joinder of Additional Parties**

16.1. Where a request is filed to consolidate multiple arbitral proceedings under these Rules, the Arbitral Tribunal may consolidate such proceedings in the following cases:

16.1.1. the Parties have consented thereto;

16.1.2. the Notices of Arbitration are made under the same arbitration agreement;

16.1.3. the Notices of Arbitration involve common questions of law and fact and arise out of the same transaction or several related transactions.

16.2. Where arbitral proceedings are consolidated, they shall be consolidated into the arbitral proceedings that were commenced first.

16.3. Where a third party applies to be joined as a new Party to the arbitral proceedings, the Arbitral Tribunal shall decide the issue taking into account the views of the Parties, the arbitration agreement, the substance of the dispute and other relevant circumstances.

үзсэнээр арбитрын ажиллагаанд оролцуулах эсэхийг шийдвэрлэнэ.

#### **17 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны хэл**

17.1. Арбитрын ажиллагааны хэлийг Талууд өөрөөр тохиролцоогүй бол монгол хэлээр явуулна.

17.2. Шаардлагатай тохиолдолд Талуудын хүсэлтийг үндэслэн арбитрын ажиллагаанд хэд хэдэн хэл хэрэглэх нөхцөл, журмыг Арбитрын бүрэлдэхүүн тодорхойлж болно.

17.3. Талууд эсхүл арбитраас тогтоосон хэлийг арбитрын бүхий л ажиллагаанд Талуудын өргөдөл, тайлбар бичих, хуралдаан явуулах, арбитрын шийдвэр, бусад мэдэгдэл гаргахад хэрэглэнэ.

17.4. Арбитрын бүрэлдэхүүн шинжээчийн дүгнэлт болон бусад бичгээр гаргасан нотлох баримтыг Талууд болон Арбитрын бүрэлдэхүүний тогтоосон хэл рүү бүхэлд нь эсхүл хэсэгчлэн орчуулахыг Талуудаас шаардана.

17.5. Талууд арбитрын ажиллагаанд хэлмэрч, орчуулагчтай оролцож болох бөгөөд энэхүү хэлмэрч, орчуулгын үнэн зөв болон хэлмэрч, орчуулгын зардлыг Талууд өөрсдөө хариуцна.

17.6. Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн хэлмэрч, орчуулагч томилж болно.

17.7. Арбитрын бүрэлдэхүүнд хэд хэдэн улсын арбитрчид орсон нөхцөлд тухайн орчуулагчаас нууц хадгалах баталгаа гаргуулан авч зөвлөлдөх тасалгаанд орчуулагчийн тусламжийг авч болно.

#### **18 дугаар зүйл Талуудын тэгш байдал**

18.1. Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох бөгөөд өөрсдийн байр

#### **Article 17. Language of the Arbitral Proceedings**

17.1. Unless the Parties have agreed otherwise, the language of the arbitral proceedings shall be Mongolian.

17.2. Where necessary, based on a Party's request, the Arbitral Tribunal may determine the conditions and procedure for using two or more languages in the arbitral proceedings.

17.3. The language agreed by the Parties or determined by the arbitral tribunal shall be used throughout the arbitral proceedings for the Parties' submissions and statements, the conduct of hearings, the arbitral award, and any other notices.

17.4. The Arbitral Tribunal shall require the Parties to provide a full or partial translation of expert opinions and other documentary evidence into the language determined by the Parties and/or the Arbitral Tribunal.

17.5. The Parties may participate in the arbitral proceedings with an interpreter and/or translator, and shall themselves be responsible for the accuracy of interpretation/translation and the costs thereof.

17.6. Where necessary, the Arbitral Tribunal may appoint an independent interpreter and/or translator.

17.7. Where the Arbitral Tribunal includes arbitrators of several countries, the Arbitral Tribunal may, upon obtaining a confidentiality undertaking from the interpreter/translator, use the assistance of the interpreter/translator in the deliberation room.

#### **Article 18. Equality of the Parties**

18.1. The Parties shall participate in the arbitral proceedings on an equal basis and shall be fully

суурийг илэрхийлэх, мэтгэлцэх боломжоор бүрэн хангагдана.

18.2. Талууд арбитрын ажиллагааны явцад болон хуралдааны үед тайлбар, хүсэлт, гомдол гаргах эрхээ эдлэх боломжтой боловч энэ эрхээ эдлээгүй дараагийн ажиллагаанд оролцсон бол эрхээ эдэлсэн гэж үзнэ.

18.3. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тэгш оролцоо, тэнцвэртэй байдлыг хангаж, арбитрын ажиллагааг цаг хугацаа, зардлын зохистой арга хэлбэрээр явуулна.

18.4. Талууд арбитрын ажиллагаанд Төлөөлөгчөөрөө дамжуулан эрх, үүргээ хэрэгжүүлж болно. Аль нэг талын Төлөөлөгч, түүний бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь арбитрын ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

18.5. Талууд болон тэдгээрийн Төлөөлөгч арбитрын ажиллагаанд Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, мөн арбитрын хуралдаанд ирээгүй, хуралдааныг орхин гарсан нөхцөлд, нөгөө талын саналыг харгалзан арбитрын ажиллагаа буюу хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.

18.6. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн Төлөөлөгч оролцуулж байгаа талын аль нэг нь Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас арбитрын хуралдаанд биечлэн болон цахимаар оролцох боломжгүй нөхцөлд тухайн этгээдийг солих боломжтой эсхүл тухайн этгээдийг оролцуулахгүйгээр хуралдааныг явуулах боломжтой бол арбитрын хуралдааныг үргэлжлүүлж болно.

18.7. Талууд өөрийн Төлөөлөгчөө боломжит хугацааны өмнө томилж, арбитрын ажиллагаанд бэлтгэх, хэргийн материал, Баримт бичиг, мэдэгдэлтэй танилцуулах, хуралдаанд оролцох боломж, нөхцөлөөр хангах үүрэг хүлээнэ. Энэхүү үүргээ

afforded an opportunity to state their positions and to present arguments.

18.2. During the arbitral proceedings and at hearings, the Parties may submit explanations, requests and complaints; however, if a Party fails to exercise such right and participates in subsequent proceedings, that Party shall be deemed to have exercised that right.

18.3. The Arbitral Tribunal shall ensure the equal participation and balanced treatment of the Parties and shall conduct the arbitral proceedings in a manner that is reasonable in terms of time and costs.

18.4. The Parties may exercise their rights and perform their obligations in the arbitral proceedings through their Representatives. A change in a Party's Representative or the composition thereof shall not constitute grounds to postpone or stay the arbitral proceedings.

18.5. Where a Party and/or its Representative fails to participate in the arbitral proceedings without Good Cause, fails to attend a hearing, or leaves the hearing, the arbitral proceedings or the hearing shall proceed in the ordinary course, taking into account the views of the other Party.

18.6. Where a Party has appointed multiple Representatives and one of them is unable, for Good Cause, to participate in the hearing in person or electronically, the hearing may proceed if that person can be replaced or if the hearing can be conducted without that person's participation.

18.7. The Parties shall appoint their Representatives sufficiently in advance and shall ensure that their Representatives are able to prepare for the arbitral proceedings, review the case file, Documents and notices, and participate in hearings. Failure to fulfil

биелүүлээгүй нь арбитрын ажиллагаанд саад болохгүй.

### **19 дүгээр зүйл. Нотлох баримт**

19.1. Талууд өөрийн нэхэмжлэл, хариу тайлбар, татгалзалд дурдсан үйл баримтыг нотлох үүрэгтэй.

19.2. Талууд нотлох баримтыг нэхэмжлэл, хариу тайлбарын хамт эсхүл Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүний тогтоосон хугацаанд ирүүлнэ. Уг хугацаанд ирүүлээгүй тохиолдолд нотлох баримтыг хүлээж авах эсэхийг Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

19.3. Нотлох баримт нь Талуудын тайлбар, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, үзлэгийн тэмдэглэл, бичмэл, цахим болон бусад хэлбэртэй байж болно.

19.4. Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр тогтоогоогүй бол Талууд гэрчийн мэдүүлгийг бичгээр гаргуулж, гарын үсэг зуруулан арбитрт ирүүлж болно. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн Талуудын хүсэлтийг үндэслэж гэрчийг хуралдаанд оролцуулах хэлбэр, журмыг тогтооно.

19.5. Талууд шинжээчийн дүгнэлтийг бичгээр гаргуулж арбитрт ирүүлж болно.

19.6. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тохиролцоог үндэслэн шаардлагатай гэж үзвэл шинжээчийг томилж болно.

19.7. Шинжээч нь нэг эсхүл хэд хэдэн шинжээчээс бүрдэж болно.

19.8. Талуудын хүсэлтийг үндэслэн үзлэг хийх арга, журмыг Арбитрын бүрэлдэхүүн тогтооно.

19.9. Арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд аливаа нотлох баримтыг нотлох чадвартай,

this obligation shall not hinder the arbitral proceedings.

### **Article 19. Evidence**

19.1. The Parties shall have the burden of proving the facts stated in the Notice of Arbitration, Answer to the Notice of Arbitration and objections.

19.2. The Parties shall submit evidence together with the Notice of Arbitration and the Answer to the Notice of Arbitration, or, unless the Parties have agreed otherwise, within the time limit set by the Arbitral Tribunal. If evidence is not submitted within such time limit, the Arbitral Tribunal shall decide whether to accept it.

19.3. Evidence may include the Parties' statements, witness testimony, expert opinions, inspection records, documentary evidence, electronic evidence and other forms of evidence.

19.4. Unless the Arbitral Tribunal decides otherwise, the Parties may submit witness testimony in writing, signed by the witness. Unless the Parties have agreed otherwise, the Arbitral Tribunal shall determine the form and procedure for witness participation at the hearing, taking into account the Parties' requests.

19.5. The Parties may submit expert opinions in writing.

19.6. The Arbitral Tribunal may appoint an expert if it considers it necessary on the basis of the Parties' agreement.

19.7. The expert may be appointed as a sole expert or as a group of one or more experts.

19.8. The Arbitral Tribunal shall determine the method and procedure for conducting an inspection, taking into account the Parties' requests.

19.9. The Arbitral Tribunal shall have the authority to determine the probative value, relevance, materiality

хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй болохыг тодорхойлох эрх хамаарна. Тухайн нотлох баримтыг хуурамч, хууль бус аргаар цуглуулсан гэж Арбитрын бүрэлдэхүүн үзвэл уг баримтыг нотлох чадваргүйд тооцож хүлээн авахаас татгалзах эсхүл үнэлэхгүй байж болно.

19.10. Талууд нотлох баримтын талаар маргаагүй тохиолдолд тухайн баримтыг нотлох чадвартай гэж үзэж болно.

19.11. Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр Талууд нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг шүүх болон бусад байгууллагад гаргаж, туслалцаа авч болно.

19.12. Арбитрын бүрэлдэхүүн нэг талын хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримт гаргах үүргийг нөгөө талд даалгаж болно.

19.13. Талууд Арбитрын бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, нотлох баримтыг Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй бол Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргаж болно.

19.14. Талууд өөрөөр тохиролцоогүй бол, эсхүл Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр шийдвэрлээгүй бол арбитрын ажиллагаанд Арбитрчдын зөвлөлөөс баталсан Нотлох баримтын журмыг баримтална.

## 20 дугаар зүйл. Арбитрын хуралдаан

20.1. Арбитрын хуралдаан нь танхим, цахим эсхүл хосолсон хэлбэртэй байж болно. Арбитрын хуралдааныг цахимаар явуулах тохиолдолд цахим хурлын удирдамжийг баримтлан явуулна.

20.2. Талууд арбитрын хуралдаанд биечлэн оролцохгүйгээр цугларсан нотлох баримтад үндэслэн маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлт гаргавал Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт

and authenticity of evidence. If the Arbitral Tribunal determines that evidence has been forged or obtained unlawfully, it may treat such evidence as inadmissible and refuse to admit it or disregard it.

19.10. If the Parties do not dispute the evidence, such evidence may be deemed to have probative value.

19.11. The Arbitral Tribunal, or the Parties with the consent of the Arbitral Tribunal, may request the assistance of a court or other competent bodies to obtain evidence.

19.12. If the Arbitral Tribunal deems a Party's request to be well-founded, it may order the other Party to produce evidence.

19.13. If the Parties fail, without Good Cause, to produce the necessary documents and evidence within the time limit set by the Arbitral Tribunal, the Arbitral Tribunal may render a decision based on the evidence available in the case file.

19.14. Unless the Parties have agreed otherwise or the Arbitral Tribunal determines otherwise, the Evidence Rules approved by the Council of Arbitrators shall apply.

## Article 20. Arbitral Hearing

20.1. The hearing may be conducted in person, remotely, or in a hybrid format. If the hearing is conducted remotely, the electronic hearing guidelines shall be followed.

20.2. Where the Parties request that the dispute be resolved on the basis of the evidence collected in the proceedings without their attendance at the hearing,

авагдсан нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэж болно.

20.3. Арбитрын хуралдаан болох огноо, газар, цагийн талаар Талуудад урьдчилан мэдэгдэнэ.

20.4. Аль нэг тал арбитрын хуралдаанд Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тохиолдолд нөгөө талын хүсэлтийг харгалзан арбитрын хуралдааныг явуулах эсэх шийдвэр гаргана.

20.5. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол арбитрын хуралдааныг хаалттай явуулна.

20.6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга дуу бичлэгийн хэлбэрээр хөтөлнө. Хэргийн оролцогчид хуралдааны явцын дууны бичлэгтэй танилцаж болно.

20.7. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг аль нэг талын хүсэлтийг үндэслэн бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тал зардлыг арбитрын үндсэн болон нэмэлт зардал тооцох журамд заасны дагуу төлнө.

20.8. Арбитрын хуралдаанаас бусад ажиллагааны явцын тэмдэглэлийг дуу, зураг, дүрс бичлэг эсхүл бичгээр нарийн бичгийн дарга хөтөлж болно.

20.9. Нарийн бичгийн дарга хуралдааны товч тэмдэглэл хөтлөх бөгөөд уг тэмдэглэлд хуралдаан явуулсан газар, эхэлсэн, дууссан цаг, оролцогчдын нэр, хуралдааны дараалал, явц, шийдвэр гаргаж танилцуулсан эсэх тухай тусгана.

20.10. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын саналыг үндэслэн үндсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалал болон цагийн хуваарийг тогтооно.

20.11. Арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэхдээ хэргийн оролцогчдын

the Arbitral Tribunal may decide the dispute on the basis of the evidence available.

20.3. The Parties shall be notified in advance of the date, place and time of the hearing.

20.4. If a Party fails to attend the hearing without Good Cause, the Arbitral Tribunal shall determine whether to proceed with the hearing, having regard to any request made by the other Party.

20.5. Unless the Parties have agreed otherwise, hearings shall be closed.

20.6. Unless the Parties have agreed otherwise, the secretary shall keep an audio record of the hearing, and participants in the arbitral proceedings may review the audio record.

20.7. Upon the request of any Party, a detailed record of the hearing may be prepared in whole or in part. The requesting Party shall bear the costs in accordance with the provisions on arbitration costs.

20.8. The secretary may keep records of other procedural actions outside the hearing by audio recording, video recording, photographing, and/or in writing.

20.9. The secretary shall keep brief minutes stating the place of the hearing, the start and end time, the names of the participants, the sequence and course of the hearing, and whether any decisions were made and announced.

20.10. The Arbitral Tribunal shall determine the agenda, order and time schedule of the main hearing, taking into account the Parties' views.

20.11. In deciding the dispute, if the Arbitral Tribunal considers that it has heard the Parties' demands,

шаардлага, тайлбар, танилцуулгыг сонсож Талуудыг тайлбар хийх, мэтгэлцэх боломжоор хангасан гэж үзсэн тохиолдолд арбитрын хуралдааныг хаана.

20.12. Арбитрын үндсэн хуралдаан хаасны дараа Арбитрын бүрэлдэхүүн үндсэн шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргах хугацааг Талуудад мэдэгдэж болно.

## **21 дүгээр зүйл. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ болон яаралтай арбитрч томилох**

21.1. Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтэд үндэслэн шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ /цаашид “түр арга хэмжээ” гэх/ авах эсхүл баталгаажуулах арга хэмжээний талаар урьдчилсан тогтоол гаргаж болно.

21.2. Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар түр арга хэмжээг өөрчлөх, дуусгавар болгох эрхтэй.

21.3. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө аль нэг тал түр арга хэмжээ авхуулах хүсэлт гаргасан бол Арбитрын эрх бүхий этгээд тухайн хүсэлтийг шийдвэрлэх яаралтай арбитрчийг 7 хоногийн дотор томилно.

21.4. Яаралтай арбитрч нь түр арга хэмжээ авхуулах хүсэлт, холбогдох баримтыг хянан үзэж, түр арга хэмжээ авах эсхүл татгалзах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана.

## **22 дугаар зүйл. Татгалзах эрхээ алдах**

22.1. Аль нэг тал нь энэ Дүрэмд зааснаас өөрөөр тохиролцох боломжтой заалтын талаар, эсхүл арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүй болохыг мэдэж байсан боловч тэр тухай даруй, эсхүл тогтоосон хугацааны дотор гомдол гаргахгүйгээр арбитрын ажиллагаанд

explanations and submissions and has afforded the Parties an opportunity to explain and present arguments, it shall close the hearing.

20.12. After closing the main hearing, the Arbitral Tribunal shall render the arbitral award and may notify the Parties of the time for rendering the arbitral award.

## **Article 21. Measures to Secure Enforcement and Appointment of an Emergency Arbitrator**

21.1. The Arbitral Tribunal may, at the request of a party, if it considers it necessary, order measures to secure enforcement (hereinafter “interim measures”) or issue a preliminary order concerning such measures.

21.2. The Arbitral Tribunal may, at the request of a party or on its own initiative, modify or terminate any interim measure.

21.3. Where, before the Arbitral Tribunal is constituted, a party applies for interim measures, the Arbitral Authority shall appoint an emergency arbitrator within 7 days to decide that request.

21.4. The emergency arbitrator shall review the request for interim measures and the relevant documents, and shall render a decision granting or refusing such interim measures within 14 days.

## **Article 22. Waiver of the Right to Object**

22.1. If a party knew that any provision of these Rules from which the Parties may derogate, or any requirement of the arbitration agreement, had not been complied with, but nevertheless continued to participate in the arbitral proceedings without promptly raising an objection or doing so within the

үргэлжлүүлэн оролцсон бол түүнийг гомдол гаргах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

prescribed time limit, that party shall be deemed to have waived its right to object.

#### ДӨРӨВ. АРБИТРЫН ШИЙДВЭР

#### CHAPTER IV. ARBITRAL DECISIONS

### 23 дугаар зүйл. Арбитрын шийдвэр, тогтоол гаргах

### Article 23. Rendering Arbitral Decisions and Orders

23.1. Хэргийг нэгээс илүү арбитрч шийдвэрлэж байгаа тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүнээс гарах аливаа шийдвэр, тогтоолыг олонхын саналаар гаргана.

23.1. Where the case is decided by more than one arbitrator, any decision or order of the Arbitral Tribunal shall be made by majority vote.

23.2. Арбитрын бүрэлдэхүүн нь Арбитрын бүрэлдэхүүнийг татгалзах хүсэлт, арбитрын харьяаллыг шийдвэрлэх тохиолдолд арбитрын шийдвэр /decision/, түр арга хэмжээ авах, эвлэрлийг баталгаажуулах, маргааныг эцэслэн шийдвэрлэх тохиолдолд арбитрын үндсэн шийдвэр /award/ гаргана.

23.2. The Arbitral Tribunal shall issue an arbitral decision /шийдвэр/ when ruling on a challenge to the composition of the Arbitral Tribunal or on arbitral jurisdiction, and an arbitral award /үндсэн шийдвэр/ when granting interim measures, confirming a settlement, or finally deciding the dispute.

23.3. Арбитрын бүрэлдэхүүн Дүрмийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд буюу арбитрын ажиллагаатай холбогдуулан тогтоол /order/, шаардлагатай тохиолдолд урьдчилсан тогтоол /preliminary order/ гаргана.

23.3. In cases other than those specified in Article 23.2 of the Rules, that is, in connection with the arbitral proceedings, the Arbitral Tribunal shall issue an order /тогтоол/ and, where necessary, a preliminary order /урьдчилсан тогтоол/.

23.4. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө эвлэрлийг баталгаажуулах хүсэлт хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Арбитрын эрх бүхий этгээдийн томилсон нэг арбитрч эвлэрлийг баталгаажуулна. Энэ тохиолдолд Дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх хэсэгт заасан журмыг баримтална.

23.4. Where, before the constitution of the Arbitral Tribunal, a request to confirm a settlement is received, a sole arbitrator appointed by the Arbitral Authority shall confirm the settlement within one week from receipt of such request. In such case, the procedure set out in Articles 21.3 and 21.4 of the Rules shall apply.

23.5. Арбитрын шийдвэр, үндсэн шийдвэр, тогтоол, урьдчилсан тогтоолыг бичгээр үйлдэх бөгөөд Талууд заавал дагаж мөрдөх, хугацаа алдалгүй биелүүлэх үүрэгтэй.

23.5. Any arbitral decision, arbitral award, order and preliminary order shall be made in writing, and the Parties shall be bound to comply with and perform them without delay.

23.6. Талууд үндэслэл заах шаардлагагүй гэж санал нэгдсэнээс бусад тохиолдолд шийдвэрийн үндэслэлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгана.

23.6. Unless the Parties have agreed that reasons are not required, the reasons for the decision shall be stated in the arbitral award.

23.7. Арбитрын үндсэн шийдвэрт Арбитрын бүрэлдэхүүн гарын үсэг зурах бөгөөд уг шийдвэр гарсан огноо болон Арбитрын ажиллагааны харьяаллыг дурдана. Аль нэг арбитрч гарын үсэг зураагүй эсхүл саналын зөрүүтэй бол энэ талаарх тайлбарыг арбитрын шийдвэрт тусгуулж болно.

23.7. The arbitral award shall be signed by the Arbitral Tribunal and shall state the date of the award and the seat of the arbitral proceedings. If any arbitrator does not sign, or if there is a dissenting opinion, that fact and an explanation may be stated in the award.

23.8. Арбитрын үндсэн шийдвэрийг арбитрын хуралдааныг хаасан эсхүл Дүгнэлт-тайлбар ирүүлснээс хойш 14 хоногийн дотор бичгээр гаргана.

23.8. The arbitral award shall be made in writing within 14 days after the closing of the hearing or the submission of the Post-Hearing Brief.

23.9. Арбитрын шийдвэр, тогтоолын эх хувийг хавтаст хэрэгт хадгалах болон Талуудад хүргэхэд хангалттай тоогоор үйлдэж Талуудад хүргэнэ.

23.9. The arbitral decision and order shall be executed in a sufficient number of originals for retention in the case file and service upon the Parties, and shall be served upon the Parties.

23.10. Арбитрын ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг Талууд бүрэн төлөх хүртэл арбитрын шийдвэр, тогтоолыг Талуудад хүргэх ажиллагааг хойшлуулж болно.

23.10. Service of the arbitral decision and order upon the Parties may be postponed until the additional costs incurred in the course of the arbitral proceedings have been paid in full by the Parties.

#### **24 дүгээр зүйл. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, нэмэлт шийдвэр гаргах, тайлбарлах**

#### **Article 24. Correction, Additional Award and Interpretation of the Arbitral Award**

24.1. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, шийдвэрийг тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах асуудлыг Арбитрын бүрэлдэхүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

24.1. The Arbitral Tribunal shall decide any issue relating to correction of the arbitral award, interpretation of the award, or the making of an additional award in accordance with the applicable law.

24.2. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухайгаа Талуудад бичгээр мэдэгдэнэ.

24.2. If the Arbitral Tribunal considers that there are no grounds to correct, interpret or make an additional award, it shall notify the Parties thereof in writing.

#### **25 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ**

#### **Article 25. Applicable Rules of Law**

25.1. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг Талууд харилцан тохиролцох бөгөөд Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн тухайн маргааныг шийдвэрлэнэ.

25.1. The Parties may agree on the rules of law applicable to the resolution of the dispute, and the Arbitral Tribunal shall decide the dispute in accordance with the rules of law agreed by the Parties.

25.2. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэх бөгөөд үүнд хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээ хамаарахгүй.

25.3. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг Талууд харилцан тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааныг шийдвэрлэхэд аль тохиромжтой гэж үзсэн материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

25.4. Талууд тусгайлан тохиролцож эрх олгосон бол Арбитрын бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр шударга гэж үзсэн хэм хэмжээг баримтлан, эсхүл эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг шийдвэрлэнэ.

25.5. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны заншил, ажил хэргийн практикийг харгалзан маргааныг шийдвэрлэж болно.

## 26 дугаар зүйл. Арбитрын зардал

26.1. Арбитрын зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэнэ.

26.2. Арбитрын үндсэн зардлыг үндсэн болон сөрөг нэхэмжлэлийн үнийн дүнгээс тооцох бөгөөд арбитрт нэхэмжлэл гаргахдаа урьдчилан төлнө.

26.3. Арбитрын ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг тухайн ажиллагааны хүсэлт гаргасан тал Арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд төлнө. Арбитрын ажиллагааг шуурхай явуулах зорилгоор арбитрын нэмэлт зардлыг холбогдох талаас

25.2. In applying the rules of law agreed by the Parties, unless otherwise expressly stated in that agreement, the Arbitral Tribunal shall construe such agreement as referring to the substantive rules of law of the relevant state, and not to procedural rules.

25.3. If the Parties have not agreed on the rules of law applicable to the resolution of the dispute, the Arbitral Tribunal shall apply the substantive rules of law it considers most appropriate for deciding the dispute.

25.4. If expressly authorised by the Parties, the Arbitral Tribunal may decide the dispute without applying any particular law, on the basis of the norms it considers fair, or by way of amiable composition.

25.5. The Arbitral Tribunal may decide the dispute having regard to the terms of the contract between the Parties and to any trade usages and business practices established in relation to the matter concerned.

## Article 26. Arbitration Costs

26.1. Arbitration costs shall consist of basic costs and additional costs.

26.2. The basic arbitration costs shall be calculated on the basis of the amount in dispute of the principal Notice of Arbitration and the counterclaim and shall be paid in advance when the Notice of Arbitration is submitted to the arbitration.

26.3. Any additional costs incurred in the course of the arbitral proceedings shall be paid, within the time limit set by the Arbitral Tribunal, by the party that requested the relevant procedural action. For the purpose of ensuring the prompt conduct of the arbitral proceedings, the arbitration office may require the

арбитрын ажлын алба урьдчилан гаргуулж болно.

relevant party to advance the additional arbitration costs.

26.4. Арбитрын үндсэн болон нэмэлт зардлын хэмжээ, түүнийг тооцох аргыг “Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээг тооцох журам”-ын дагуу тогтооно.

26.4. The amount of the basic arbitration costs and additional costs, and the method of calculating them, shall be determined in accordance with the “Rules for Calculating Basic Arbitration Costs and Additional Costs”.

## **27 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа дуусгавар болох**

## **Article 27. Termination of the Arbitral Proceedings**

27.1. Арбитрын ажиллагаа нь арбитрын үндсэн шийдвэр /award/ эсхүл энэ Дүрмийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3-т заасан үндэслэлээр тогтоол гарснаар арбитрын ажиллагаа дуусгавар болно.

27.1. The arbitral proceedings shall terminate upon the rendering of an arbitral award /үндсэн шийдвэр/ or upon the issuance of an order on the grounds set out in clauses 27.2 and 27.3 of this Article.

27.2. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дараах тохиолдолд дуусгавар болгоно:

27.2. The Arbitral Tribunal shall terminate the arbitral proceedings in the following cases:

27.2.1. арбитрын харьяаллын маргаан биш болох нь тогтоогдсон;

27.2.1. it is established that the matter is not a dispute subject to arbitral jurisdiction;

27.2.2. эрхийн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;

27.2.2. the Notice of Arbitration has been filed by a person lacking legal capacity or authority to represent;

27.2.3. нэхэмжлэлд дурдсан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн буюу арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол;

27.2.3. there is a final and binding court judgment or arbitral award resolving the matter stated in the Notice of Arbitration;

27.2.4. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, нэхэмжлэлээ татан авсан, Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, биелүүлсэн;

27.2.4. the Claimant has waived or withdrawn its claim as set out in the Notice of Arbitration, or the Respondent has accepted or satisfied the relief sought in the Notice of Arbitration;

27.2.5. Талууд эвлэрсэн;

27.2.5. the Parties have reached a settlement;

27.2.6. Талууд арбитрын зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй;

27.2.6. the Parties have failed to pay the arbitration costs within the prescribed time limit;

27.2.7. бусад шалтгааны улмаас арбитрын ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагагүй эсхүл боломжгүй болсон.

27.2.7. for other reasons, continuation of the arbitral proceedings has become unnecessary or impossible.

27.3. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, Талууд арбитрын ажиллагааг дуусгавар болгох талаар хүсэлт гаргасан, эсхүл Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан бол Арбитрын эрх бүхий этгээд арбитрын ажиллагааг дуусгавар болгоно.

27.4. Талууд эвлэрсэн тохиолдолд эвлэрлийг арбитрын үндсэн шийдвэрээр баталгаажуулах хүсэлт гаргаж болно. Хэрэв арбитрын шийдвэрээр баталгаажуулах шаардлагагүй гэж үзвэл Арбитрт бичгээр мэдэгдэнэ.

27.3. Before the Arbitral Tribunal is constituted, if the Claimant withdraws the claim as set out in the Notice of Arbitration, the Parties request termination of the arbitral proceedings, or the Respondent has fully satisfied the relief sought in the Notice of Arbitration, the Arbitral Authority shall terminate the arbitral proceedings.

27.4. Where the Parties have settled, they may request that the settlement be confirmed by an arbitral award. If they do not require such confirmation, they shall notify the Arbitration Centre in writing.

## ТАВ. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

## CHAPTER V. OTHER PROVISIONS

### 28 дугаар зүйл. Түргэвчилсэн ажиллагаа

### Article 28. Expedited Procedure

28.1. Нэхэмжлэлийн үнийн дүн 50,000,000 /тавин сая/ төгрөг болон түүнээс доош бол арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулна.

28.1. Where the amount in dispute of the Notice of Arbitration is MNT 50,000,000 /fifty million/ or less, the arbitral proceedings shall be conducted under the expedited procedure.

28.2. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө нэхэмжлэлийн үнийн дүнгээс үл хамааран Талууд арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар харилцан тохиролцож болно.

28.2. Before the Arbitral Tribunal is constituted, the Parties may, irrespective of the amount in dispute, mutually agree that the arbitral proceedings shall be conducted under the expedited procedure.

28.3. Түргэвчилсэн ажиллагаанд дараах журмыг баримтлах бөгөөд Дүрмийн бусад холбогдох заалтууд мөн үйлчилнэ:

28.3. The following procedure shall apply to the expedited proceedings, and the other relevant provisions of these Rules shall also apply:

28.3.1. арбитрын хэлэлцээрт гурван арбитрчаар маргааныг шийдвэрлүүлнэ гэж харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд маргааныг нэг арбитрч шийдвэрлэх бөгөөд тухайн арбитрчийг Арбитрын эрх бүхий этгээд томилно;

28.3.1. unless the Parties have agreed in the arbitration agreement that the dispute shall be decided by three arbitrators, the dispute shall be decided by a sole arbitrator appointed by the Arbitration Centre authority;

28.3.2. Талууд арбитрын хэрэг үүсгэсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор арбитрын ажиллагаа явуулах журмыг тогтооход энэхүү Дүрмийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасан асуудлаар өөрсдийн саналыг ирүүлэх үүрэгтэй;

28.3.2. within 7 days after receipt of the notice of commencement of the arbitration, the Parties shall submit their proposals on the matters specified in clause 13.5 of these Rules for the purpose of determining the procedure for conducting the arbitral proceedings;

28.3.3. арбитрч арбитрын ажиллагааг явуулах журмыг Талуудын урьдчилан бичгээр ирүүлсэн саналын үндсэн дээр тогтоох бөгөөд хэрэв Талууд санал зөрвөл арбитрч өөрөө тогтооно;

28.3.3. the arbitrator shall determine the procedure for conducting the arbitral proceedings on the basis of the Parties' prior written proposals, and if the Parties' proposals differ, the arbitrator shall determine the procedure;

28.3.4. арбитрч арбитрын ажиллагаа явуулах журмыг бичгээр гарган, гарын үсэг зуран баталгаажуулж Талуудад хүргэнэ;

28.3.4. the arbitrator shall set out the procedure for conducting the arbitral proceedings in writing, sign it and serve it on the Parties;

28.3.5. арбитрын хуралдааныг зайлшгүй тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн нэг удаа хойшлуулж болно;

28.3.5. the Arbitral Tribunal may adjourn the hearing once where unavoidable;

28.3.6. арбитрч арбитрын ажиллагаанд Дүрмийн 28 дугаар зүйлийн 28.3.4 дэх заалтад заасан журмын дагуу явуулж хэргийг шийдвэрлэнэ;

28.3.6. the arbitrator shall conduct the arbitral proceedings in accordance with clause 28.3.4 of this Article and decide the case;

28.3.7. Арбитраас хэргийн материалыг Арбитрын бүрэлдэхүүнд хүргэснээс хойш 60 хоногийн дотор арбитрын үндсэн шийдвэр гаргана. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн уг хугацааг нэг удаа сунгаж болно.

28.3.7. The arbitral award shall be rendered within 60 days after the Arbitration Centre transmits the case materials to the Arbitral Tribunal. Where absolutely necessary, the Arbitral Tribunal may extend that period once.

28.3.8. Маргаан шийдвэрлэх арбитрч томилогдсоны дараа нэхэмжлэлийн үнийн дүн 50,000,000 /тавин сая/ төгрөгөөс дээш үнийн дүнтэй болсон нь арбитрын ажиллагаа болон арбитрчийн тоог өөрчлөх үндэслэл болохгүй. /Энэ заалтыг МОУА-ын Арбитрчдын зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 5 дугаар тогтоолоор нэмсэн./

28.3.8. An increase in the amount in dispute to more than MNT 50,000,000 /fifty million/ after the arbitrator deciding the dispute has been appointed shall not constitute grounds for changing the arbitral proceedings or the number of arbitrators. /This clause was added by Resolution No. 5 dated 6 February 2026 of the Council of Arbitrators of the Arbitration Centre./

## 29 дүгээр зүйл. Нууцлал

## Article 29. Confidentiality

29.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн, Арбитр, Талууд болон хэргийн оролцогч, арбитрын ажиллагааны талаар болон нотлох баримтын талаарх нууцыг хадгалах үүрэгтэй.

29.1. Unless the Parties agree otherwise, the Arbitral Tribunal, the Arbitration Centre, the Parties and the participants in the case shall be obliged to preserve the confidentiality of information relating to the arbitral proceedings and the evidence.

29.2. Арбитраас арбитрын шийдвэрийг Талууд болон Арбитрын бүрэлдэхүүний зөвшөөрөлтэйгөөр хэвлэн нийтэлж болно.

29.2. The Arbitration Centre may publish the arbitral decision with the consent of the Parties and the Arbitral Tribunal. It may also publish information

Мөн арбитрын ажиллагаанд оролцсон этгээдүүдийн нэр болон бусдад танигдах байдлыг нууцлан арбитрын ажиллагааны талаар мэдээлэн, хэвлэн нийтэлж болно.

concerning the arbitral proceedings while keeping confidential the names of the persons who participated in the arbitral proceedings and any identifying details.

### 30 дугаар зүйл. Хариуцлага

### Article 30. Liability

30.1. Арбитрч нь хэрэг хянан шийдвэрлэх үедээ гаргасан санал, шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй.

30.1. An arbitrator shall not bear liability for any opinion expressed or decision rendered in the course of deciding the case.

ooOoo

ooOoo

#### Legal Notice

This is an unofficial translation for informational purposes only and does not constitute legal advice. The author accepts no liability for any action taken solely in reliance on this translation unless separate legal advice on the application of the Rules has been provided by the author pursuant to a specific engagement agreement. For inquiries regarding such legal advice, please contact the author via LinkedIn: <https://www.linkedin.com/in/alexander-dondokov/>